

257

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 4 дугаар
сарын 20 -ний өдөр

Дугаар 129 / 100

Улаанбаатар хот

Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журмын тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24.2, 24.6.7 заалтуудыг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1. “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”-ыг нэгдүгээр, “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ын 2.4.4-т заасан эмийн төсвийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн төсөвт, 2.4.9-т заасан эмийн төсвийг Улсын клиникийн төв эмнэлгийн төсөвт, мөн 2.4.11-т заасан эмийн төсвийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн жил бүрийн төсөвт улсын хэмжээний хэрэгцээг тооцон тусгахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Д.Отгонбаатар/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч.Мөнхдэлгэр/-т, Сангийн яамны Төсвийн бодлогын газар (Б.Батжаргал)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 393 тоот тушаалын гурав, дөрөвдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД


Н.ХҮРЭЛБААТАР

САНГИЙН САЙД


Д.ХАЯНХЯРВАА

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын
2012 оны 22/100 тоот хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨЛБӨРИЙГ НЬ ТӨР ХАРИУЦАХ ЭМИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн төлбөрийг төр хариуцаж иргэнд үнэ төлбөргүйгээр олгох асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн захиргаа төлбөрийг нь төр хариуцах эмийн зардлыг жил бүр эмнэлгийнхээ төсөвт тусад нь дэд зүйл анги болгож тусган уг эмээр тасралтгүй хангах асуудлыг хариуцна.
- 1.3. Энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт"-ын дагуу тухайн жилийн эхэнд нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр улирал тутам оношийг нь баталгаажуулж нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байлгана.
- 1.4. Төр хариуцах сүрьеэгийн эмээс бусад эмийг амбулаториор олгохдоо 1.3-т заасны дагуу эмчийн хяналтад байгаа өвчтөнд нэг сарын хугацаанд хэрэглэгдэх эмийг сар бүр олгоно. Сум, багт амьдарч буй өвчтөнд 3 сар хэрэглэх хэмжээний эмийг олгож болох бөгөөд зохицуулалтын асуудлыг тухайн өвчтнийг хяналтанд авсан эмнэлэг хариуцна.
- 1.5. Эм олгох үйл ажиллагааг 1.2-т заасан эмнэлгийн байгууллагын эмийн сан гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд төр хариуцах эмийг олгох үйл ажиллагааг сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгээр гүйцэтгүүлж болох бөгөөд аймгийн Эрүүл мэндийн газар зохицуулалтыг хийж, төсөв хуваарилах, эмээр хангах ажлыг зохион байгуулна.
- 1.6. Өвчтөний хяналтыг хариуцсан эмч эмийн жорын стандарт MNS 5376:2008-аар батлагдсан жорын маягтад эмийг бичиж, эмчилгээ, хяналтын картанд нь тэмдэглэнэ.
- 1.7. Эдгээр эмээр эмчлэх явцад тунг өвчтөн бүрт эмчлэгч эмч тохируулж, хэрэглээнд хяналт тавина.
- 1.8. Иргэн оршин суугаа газраасаа шилжсэн тохиолдолд эмчилгээ хийж байсан эмнэлгийн байгууллага нь шилжүүлэг хийж өгөх бөгөөд шилжин очсон газрынх нь харъяалалын эмнэлгийн байгууллага түүнийг бүртгэн авч эмчилгээг нь чирэгдэлгүй үргэлжлүүлнэ.

1.9. Эмнэлгийн байгууллагууд төлбөрийг нь төр хариуцах эмийн зарцуулалтын тайланг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст улирал тутам гаргаж ирүүлнэ.

1.10. Амбулаториор төлбөрийг нь төр хариуцах эмийг зориулалтаас гадуур зарцуулсан тохиолдолд гэм буруутай этгээдэд хуулийн дагуу хариуцлага хvlээлгэнэ.

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын
2012 оны 129/100 тоот хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨЛБӨРИЙГ НЬ ТӨР ХАРИУЦАН АМБУЛАТОРИОР ЭМЧЛЭХ ӨВЧИН, ЭМГЭГ БА ТҮҮНД ХЭРЭГЛЭХ ЭМИЙН ЖАГСААЛТ

2.1. Сүрьеэ

- Пиразинамид (шахмал 500 мг)
- Этамбутол (шахмал 100 мг, 275 мг, 400 мг)
- Рифамицин (капсул/шахмал 150 мг, 300 мг)
- Изониазид (шахмал 50 мг, 75 мг, 100 мг, 300 мг)
- Стрептомицин (тарилгын нунтаг 1 гр. флаконтой)
- Эдгээр эмийн хослол

2.2. Хорт хавдрын гурав, дөрөвдүгээр ve шат (хөнгөвчлөх эмчилгээ)

- Морфин, даруй сулардаг (шахмал 10 мг)
- Морфин, удаан сулардаг (шахмал 30 мг)
- Морфин (тарилгын уусмал 1% 1 мл тун шилтэй)
- Трамадол (капсул 50 мг, шахмал 100мг, дусал)
- Тармадол (50 мг/мл, 75 мг/3мл, 100 мг/2мл тун шилтэй)
- Кодеинфосфат (шахмал 30 мг)
- Кодеинфосфат 30 мг+Парацетамол 500мг (шахмал)

2.3. Сэтгэцийн эмгэг

- Амитриптиллин (шахмал 25 мг)
- Галоперидол (шахмал 1.5 мг, 5 мг)
- Диазепам (шахмал 2 мг, 5 мг, 10мг)
- Литийн карбонат (капсул/шахмал 300 мг, 500 мг)
- Метадон (шахмал 5 мг, тарилгын уусмал 10 мг/мл)
- Хлорпромазин (шахмал 100 мг)
- Фенобарбитал (шахмал 15 мг, 30 мг, 100 мг)
- Флуфеназин (тарилгын уусмал 25 мг/мл)
- Левомепромазин (шахмал 25 мг)

2.4. Удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэг

2.4.1. Чихрийн шижин

- Инсулин (тарилгын уусмал 100 ОУН/мл-3 мл/пенфил, 10 мл/фл.)
 - Хэт богино хугацааны үйлдэлтэй инсулин
 - Богино хугацааны үйлдэлтэй инсулин
 - Дунд хугацааны үйлдэлтэй инсулин
 - Урт хугацааны үйлдэлтэй инсулин
 - Холимог инсулин
- Глибенкламид (шахмал 2.5 мг, 5 мг)
- Метформин (шахмал 500 мг, 850 мг)

- Гликлазид (шахмал 30 мг, 80 мг)

2.4.2. Чихрийн бус шижин

- Десмопрессин / минирин (шахмал 0.1 мг, 5 мл хамрын дусаалга)

2.4.3. Бамбай булчирхайн дутмагшил (гипотиреоз)

- Левотироксин (шахмал 25 мг, 50 мкг)
- Триодтрионин (шахмал 20 мкг)

2.4.4. Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил

- Соматропин (үзгэн тариур 10мг/1,5 мл)

2.4.5. Паркинсоны өвчин

- Левадопа+Карбидопа (шахмал 100 мг+10 мг, 250+25 мг)

2.4.6. Уналт таталт (Эпилепси)

- Карбамазепин (шахмал 200 мг)
- Вальпроны хүчил (шахмал 200 мг, 500 мг)

2.4.7. Миастени

- Неостигмин (шахмал 10 мг, тарилгын уусмал 500 мкг/мл)
- Галантамин (тун шил 1% 0,25-1 мл)

2.4.8. Нүдний даралт ихсэх өвчин (Глаукома)

- Пилокарпин (нүдний дусал 2%, 4%)
- Тимолол (нүдний дусал 0,25%, 0,5%)

2.4.9. Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал

- Такролимус (капсул 0,5 мг, 1 мг, 5 мг)
- Циклоспорин (капсул 25 мг)

2.4.10. Дархлалын олдмол хомсдол өвчин

- Ацикловир (шахмал 200 мг, 400 мг, 800 мг)
- Зидовудин /AZT/ (капсул 100 мг, 250 мг)
- Ламивудин /ЗТС/ (шахмал 150 мг, 300 мг)

2.4.11 Гемофилии

- Гемофилийн эсрэг фактор (хуурай фактор VIII, IX – 250 ОУН-3000 ОУН)